



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 21

Шарга

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.13 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Хүүхдийн цэцэрлэгийн 2014-2016 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг тайлагнаж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч /О.Гүнрэгжав/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Ч.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР



00037

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014
оны 06 дугаар сарын 04-ний
21 дугаар тогтоолын Хавсралт

ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР 2011-2016

Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг Монгол Улсын нийгэм эдийн засаг, хүний хөгжлийн талаарх суурь бодлоготой уялдуулан төр, засаг захиргааны болон боловсролын тогтолцооны бүтцэд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Шинэ мянган, шинэ зуунд сурч хөгжих бяцхан шавь нарынхаа хөгжих тэгш эрхийг хангах замаар сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх, сургуульд бэлтгэх таатай орчныг бүрдүүлэхэд энэхүү төлөвлөгөөний зорилго оршино.

Стратеги төлөвлөгөөг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр цэцэрлэгийн ирээдүйн дүр төрх өнөөгийн байгаа түвшнээс дээшилж, боловсролын шинэчлэлд хувь нэмэр оруулан Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүн дээшлэх юм. Төлөвлөгөөнд тусгагдсан багш, ажилтан, эцэг эх, төрийн бус байгууллага, олон нийтийн дэмжлэг туслалцааны үр дүнд хэрэгжүүлэх болно.

Товч танилцуулга

Тус цэцэрлэг нь 1964 онд хувийн гэрт 10 хүүхэд 1 ажилтантай анх байгуулагдсан. Одоо 90 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай зориулалтын барилга байгууламжтай, 20 багш, ажилчидтай, 5 бүлэгт 230 хүүхэд хүлээн авч ажил үйлчилгээ явуулж байна. Мөн нүүдлийн болон явуулын багшийн сургалт зохион байгуулж ажиллаж байна. Хөдөөгийн 5 баг, сумын 1 баг нийт 6 багийн айл өрхийн 2-5 хүртэлх насны хүүхдүүдийг Сургуулийн өмнөх боловсролд хамруулах үүрэг хүлээж ажилладаг.

Цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө 50 хэм хүрч хүйтэрдэг. Тус сум нь аймгийн төвөөс 138 км зайд алслагдсан. 5000 гаруй хүн амтай. Малаараа аймагт тэргүүлдэг.

Алсын хараа

Боловсон хүчний чадавх сайтай, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн "Хүүхдэд ээлтэй цэцэрлэг" болно.

Эрхэм зорилго:

Хүүхэд бүрийн авъяас чадварыг нээн хөгжүүлж, хүмүүний зан чанарын үнэт зүйлсийн суурийг эзэмшүүлэх, өв уламжлалаа дээдлэн хүндэтгэдэг зөв монгол хүүхдийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд бидний эрхэм зорилго оршино.

Эрхэмлэх зарчим:

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг бага насны хүүхэд болон иргэд олон нийтэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ хүүхэд нэг бүрийн авъяасыг хөгжүүлэн тэднийг бүтээлч сэтгэлгээтэй иргэн болгон төлөвшүүлнэ.

Орчны шинжилгээ /SWOT/

	"S" Давуу тал	"W" Сул тал
Дотоод орчин	<ul style="list-style-type: none">• Өрсөлдөх чадвар сайн• Тэс бүсийн төв• Зориулалтын барилга байгууламжтай нэгдсэн уурын халаалт, агаарын цахилгаан шугамд холбогдсон• Интернетэд холбогдсон• Багшлах боловсон хүчнээр хангагдсан	<ul style="list-style-type: none">• Цэцэрлэгийн насны хүүхдийг Сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулахад барилгын хүчин чадал хүрэлцээгүй• Цэвэр бохир усны системд холбогдоогүй• Тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай• Хүнс хадгалах агуулах зоорьгүй• Хүүхэд, эцэг эхийн хандлага төлөвшил дутмаг
Гадаад орчин	<p>"O" Боломж</p> <ul style="list-style-type: none">• Өргөтгөл болон цэцэрлэг барих газартай• Бүсийн төв тул бусад сумдын цэцэрлэгүүдийг урьж хамтран ажиллаж туршлага судлах• Цахимаар шаардлагатай	<p>"T" Бэрхшээл</p> <ul style="list-style-type: none">• Зөөврийн ус нь ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангадаггүй• Орчин үеийн Ухаалаг самбар, проектер, өндөр хурдтай компьютер, зөөврийн компьютергүйгээс хүүхэд багш

11. "S-5,O-4" Багшлах боловсон хүчин хүрэлцээтэй байгаа тул хувилбарт сургалт зохион байгуулж хамран сургалтыг нэмэгдүүлэх

Стратегийн зорилтууд:

Бага насны хүүхдийг хөгжүүлэхэд туслах зорилгоор тэдэнд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох, тэдний сурч хөгжих ээлтэй орчин бүрдүүлэхэд нөөц боломжоо ашиглан ажиллах

ЗОРИЛТ-1: Хамран сургалтыг нэмэгдүүлэх

Хамран сургалтын бохир жинг 99,0%-д хүргэх. Үүнээс хамран сургалтын 64%-ийг өдрийн цэцэрлэгээр, хувилбарт сургалтаар 35%-ийг хамруулна.

ЗОРИЛТ-2: Барилгын хүчин чадлыг нэмэгдүүлэх

100 ортой цэцэрлэгтэй болох

ЗОРИЛТ-3: Нэг багшид ногдох хүүхдийн тоог 25-д хүргэх

ЗОРИЛТ-4: Бүлгийн үндсэн багшийг 100% мэргэжлийн багштай болгох

ЗОРИЛТ-5: Багш нарыг сургалтын техник хэрэгслээр хангах, мэргэжил боловсролыг дээшлүүлэх

ЗОРИЛТ-6: Багш нарыг 100% "Багшлах эрх"-тэй болгох

ЗОРИЛТ-7: Төсөл хөтөлбөрт хамрагдаж материаллаг баазаа бэхжүүлэх

ЗОРИЛТ-8: Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх

ЗОРИЛТ-9: Хүүхдэд ээлтэй цэцэрлэг болох

ЗОРИЛТ-10: Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын 1 дүгээр зэргийн болзол хангах

Боловсролын тулгамдсан асуудлууд

Хүртээмж:

1. Ядуу өрхийн хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж хязгаарлагдмал байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж сул байна.